



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/16

Арвайхээр сум

Чанарын менежментийн тогтолцооны чанарын бодлого батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, MNS ISO 9001:2016 “Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага” стандарт, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний журмын 4.7.3, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн “Чанарын менежментийн тогтолцооны бодлого”, “Алсын хараа”, “Эрхэм зорилго”, “Стратегийн зорилт”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.


2.Батлагдсан “Чанарын менежментийн тогтолцооны бодлого”-ыг байгууллагын хэмжээнд мөрдлөг болгон хэрэгжүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Сургалт хөгжил, бодлого төлөвлөлт гүйцэтгэлийн албаны дарга, менежментийн тогтолцооны менежер (Д.Аззаяа), Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга (Ц.Лувсандамдин), тасаг, нэгжийн дарга, менежер нарт тус тус үүрэг болгосугай.

3.Батлагдсан чанарын бодлогыг нийт ажилтанд танилцуулах, өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, сонирхогч талуудад мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Сургалт хөгжил, бодлого төлөвлөлт гүйцэтгэлийн алба болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд даалгасугай.

4.Чанарын менежментийн тогтолцооны бодлогын хэрэгжилт, үр нөлөөг жил бүр үнэлж, удирдлагын дүн шинжилгээнд хэлэлцүүлэн, шаардлагатай сайжруулалтыг хийж ажиллахыг Сургалт хөгжил, бодлого төлөвлөлт гүйцэтгэлийн албаны дарга, менежментийн тогтолцооны менежерт даалгасугай.

5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирлын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/16 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ  Д.ДАШЖАНЦАН



Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
захирлын 2026 оны 02 дугаар сарын 09
өдрийн 44 дугаар тушаалын хавсралт

ЭРХЭМ ЗОРИЛГО :

ОЛОН УЛСЫН СТАНДАРТ БОЛОН ЭМНЭЛ ЗҮЙН НОТОЛГООНД СУУРИЛСАН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ ҮЗҮҮЛЭХ.

АЛСЫН ХАРАА :

ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭ, СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВ ЖИШИГ ТӨВ БОЛНО.

УРИА:

ЭРҮҮЛИЙГ ХАМТДАА

ҮНЭТ ЗҮЙЛ :

- ХАРИЛЦАГЧ ТӨВТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ИРГЭН, БАЙГУУЛЛАГА)
- МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙТЭЙ, ЧАДВАРЛАГ ХАМТ ОЛОН
- ЭЕРЭГ ХАРИЛЦАА, ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДЛАГА

СТАРТЕГИ ЗОРИЛГО:

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ НЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИАР ТӨРӨЛЖСӨН НАРИЙН
МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ
ЧАНАРТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЗҮҮЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ТАСРАЛТГҮЙ
САЙЖРУУЛАЛТ-ЫГ ХЭРЭГЖҮҮЛДЭГ САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА БАЙНА.